



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/123

Номгон


Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн
судалгаа хийхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XII дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/55 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх хавсралтын 9 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн судалгаа хийхэд хөрөнгө зарцуулсугай.

2. Судалгаа хийхэд шаардагдах төсөв болох 15.000.000 (Арван таван сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

042310295